



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/343

Есөнбулаг

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын 2.1.1 дэх заалт, аймгийн Онцгой комиссын 2024 оны 11 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Ган зудын эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх арга хэмжээг орон нутгийн хэмжээнд зохион байгуулахыг Ус, цаг уур орчны шинжилгээний төв (Н.Алтантуяа)-д үүрэг болгосугай.

2.Дээрх үйл ажиллагаанд шаардагдах 15,000,000 (арван таван сая) төгрөгийг Улсын онцгой комиссоос хуваарилсан хөрөнгийн эх үүсвэрээс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3.Цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж, дүнг 2024 оны 09 дүгээр сарын 15-ны дотор Засаг даргын Удирдлагын зөвлөлд танилцуулахыг Ус, цаг уур орчны шинжилгээний төв (Н.Алтантуяа)-д даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР